



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 02 сарын 18 өдөр

Дугаар А/26

Улаанбаатар хот

Эдийн засгийн секторын ангилал
батлах тухай

Монгол Улсын “Статистикийн тухай” хуулийн 12 дугаар зүйлийн 3 дугаар хэсгийн 3 дахь заалт, Үндэсний статистикийн хорооны даргын зөвлөлийн 2015 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. “Эдийн засгийн секторын ангилал”-ыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

Хоёр. “Эдийн засгийн секторын ангилал”-ыг мөрдөн ажиллахыг Макро эдийн засгийн статистикийн газар /Э.Эрдэнэсан/-т үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргаа удирдлагын газар /Г.Гантөмөр/-т үүрэг болгосугай.

Дөрөв. Энэ тушаал гарсантай холбогдуулан Үндэсний статистикийн хорооны даргын 2008 оны 04 сарын 24-ний өдрийн 1/57 тоот тушаалыг 2015 оны 2 дугаар сар 18-ны өдрөөс хүчингүйд тооцсугай.

ДАРГА



С.МЭНДСАЙХАН



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

ҮСХ-ны даргын 2015 оны ᠒ дугаар сарын 18-ний
өдрийн 126 тоот тушаалаар батлав.



ЭДИЙН ЗАСГИЙН СЕКТОРЫН АНГ АЛ Л

Улаанбаатар хот
2015 он

Агуулга

Нэг. Нийтлэг үндэслэл

Хоёр. Ойлголт, тодорхойлолт

Гурав. Эдийн засгийн нэгж, түүний төрөл

Дөрөв. Эдийн засгийн секторын ангилал (S1)

3.1 Санхүүгийн бус сектор /S.11/

3.1.1 Төрийн өмчит санхүүгийн бус үйлдвэрийн газар (S.111)

3.1.2 Хувийн хэвшлийн санхүүгийн бус ААНБ (S.112)

3.1.3 Гадаадын эзэмшлийн санхүүгийн бус ААНБ (S.113)

3.2 Санхүүгийн сектор /S.12/

3.2.1 Төв банк (S.121)

3.2.2 Төв банкнаас бусад хадгаламжийн байгууллага (S.122)

3.2.3 Мөнгөний захын хөрөнгө оруулалтын сан (S.123)

3.2.4 Мөнгөний захын бус хөрөнгө оруулалтын сан (S.124)

3.2.5 Тэтгэврийн сан, даатгагчаас бусад санхүүгийн зуучлагч (S.125)

3.2.6 Санхүүгийн туслах үйлчилгээ эрхлэгч (S.126)

3.2.7 Кэптив санхүүгийн байгууллагууд болон мөнгө зээлдүүлэгч (S.127)

3.2.8 Даатгагч (S.128)

3.2.9 Тэтгэврийн сан (S.129)

3.3 Төрийн байгууллагын сектор /S.13/

3.3.1 Төрийн төв байгууллага /S.131/

3.3.2 Бүсийн удирдлага /S.132/

3.3.3 Орон нутгийн удирдлага /S.133/

3.3.4 Нийгмийн хамгааллын сан /S.134/

3.4 Өрхийн аж ахуйн сектор /S.14/

3.4.1 Ажил олгогч (S141)

3.4.2 Хувиараа хөдөлмөр эрхлэгч (S142)

3.4.3 Хөлсний ажиллагчид (S143)

3.4.4 Өмчийн болон шилжүүлгийн орлого хүртэгчид (S144)

3.5 Өрхөд үйлчилдэг АББ-ын сектор /S.15/

3.5.1 Гишүүддээ үйлчилдэг АББ (S.151)

3.5.2 Хүмүүнлэгийн үйл ажиллагаа эрхэлдэг АББ (S.152)

3.5.3 Хамтын үйлчилгээ үзүүлдэг АББ (S.153)

Дөрөв. Гадаад эдийн засгийн сектор (S2)

Хавсралт 1. YTC 2008-д орсон холбогдох гол өөрчлөлт

Хавсралт 2. МУ-ын нутаг дэвсгэрт харьяалах ААНБ-ыг сектороор ангилах нь

Хавсралт 3. YTC-1993 болон YTC-2008-ийн ЭЗС-н ангиллын харьцуулалт

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
АБ	Ашгийн байгууллага
АББ	Ашгийн бус байгууллага
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ӨАА	Өрхийн аж ахуй
ОУВС	Олон улсын валютын сан
ӨҮАББ	Өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ҮТС	Үндэсний тооцооны систем

Нэг. Нийтлэг үндэслэл

Үндэсний тооцооны систем (ҮТС)-д үйлдвэрлэл, үйлчилгээний анхдагч нэгжүүдийг эдийн засгийн салбарын болон секторын гэсэн үндсэн 2 ангилалд хуваан авч үздэг бөгөөд улс орнуудын түвшинд эдийн засгийн секторын ангиллыг салбарын ангиллын нэг адил өргөн хэрэглэж байна.

Энэхүү ангилал нь эдийн засаг дахь санхүүгийн урсгал, орлого, зарлагыг эдийн засгийн сектороор харуулах зорилготой бөгөөд эдийн засгийн нэгжүүд ямар үйл ажиллагаа эрхэлж байгаа нь гол бус харин орлого, эцсийн хэрэглээ, санхүүгийн үйл ажиллагаатай хэрхэн холбогдож байгааг гол шалгуур болгоно.

ҮТС-д секторын ангилал, түүнд тулгуурлаж хийсэн тооцоо чухал ач холбогдолтой. Нийт үйлдвэрлэл, ДНБ, үндэсний тооцооны дансууд, макро эдийн засгийн бусад үзүүлэлтийг секторын ангиллаар гаргаж нийт эдийн засагт тухайн секторын эзлэх байр суурийг тодорхойлно. Энэ нь эдийн засгийг үйлдвэрлэгчдийн бүтэц талаас харуулахаас гадна эдийн засгийн секторын талаар төрийн бодлогыг тодорхойлоход практик ач холбогдолтой.

ҮТС-д дотоодын эдийн засгийг олон улсын түвшинд түгээмэл мөрдөж байгаа үндсэн 5 секторт ангилж эдгээр секторт улс орны эдийн засгийн бүх нэгжийн үйл ажиллагааг бүрэн хамруулна. Түүнчлэн эдийн засгийн секторын ангилалд гадаад эдийн засгийн секторыг бие даасан бүлэг болно.

Үйлдвэрлэл, үйлчилгээний анхдагч аж ахуйн нэгж, байгууллагыг эдийн засгийн секторын ангиллаар ангилахад энэхүү ангиллыг мөрдлөг болгоно. Мөн эдийн засгийн дансуудыг сектороор байгуулахад ашиглана.

ҮТС 93 зөвлөмжид үндэслэн боловсруулсан “Эдийн засгийн секторын ангилал”-ыг 2008 онд батлуулан мөрдөж байна.

Манай улс ҮТС 2008 зөвлөмжид орсон өөрчлөлтийг үндэсний аргачлалдаа үе шаттайгаар тусгах ажлын хүрээнд уг зөвлөмжид орсон статистик нэгжийн ойлголт, тодорхойлолт болон эдийн засгийн секторын ангилалд гарсан өөрчлөлт, ялангуяа санхүүгийн зах зээл, санхүүгийн үүсмэл хэрэгсэлийн хөгжилтэй холбоотой гарсан өөрчлөлтийг тусган, “Эдийн засгийн секторын ангилал”-ыг шинэчлэх шаардлага гарсан.

ҮТС 2008-д орсон Эдийн засгийн секторын ангилалтай холбоотой өөрчлөлтийг Хавсралт 1-д харуулав.

Хоёр. Ойлголт, тодорхойлолт

Эдийн засгийн нэгж

Эдийн засгийн нэгж нь өөрийн эрхийн хүрээнд өмч эзэмших, өр төлбөр үүсгэх, эдийн засгийн үйл ажиллагаанд оролцох, бусад хуулийн этгээдтэй ажил гүйлгээ хийх чадвартай нэгж юм.

Эдийн засагт зохион байгуулалтын үндсэн 2 нэгж байдаг.

- Өрх (өрхийн аж ахуй эрхлэгчид)
- Хуулийн этгээд (аж ахуйн нэгж, байгууллага)

Өрх

Нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын бусад хэрэгцээгээ хамтран хангадаг хэсэг бүлэг хүмүүсийг өрх гэнэ. Өрхийн гишүүд нь хоорондоо гэр бүл, ураг төрөл болон хамаатан садны холбоотой хүмүүс, зарим гишүүд нь огт хамааралгүй байж болно. ([Хүн ам, орон сууцны тооллогод хэрэглэсэн тодорхойлолт](#))

Өрх нь нэг орон байранд амьдарч, орлого болон өмч хөрөнгөө бүгдийг нь эсвэл заримыг нь нийлүүлэн, тодорхой бараа үйлчилгээг, ихэвчлэн орон байр болон хоол хүнсээ хамтран хэрэглэдэг бүлэг хүмүүс юм. Энд мөн эмнэлэг, өндөр настны асрамжийн газар, хорих газар зэрэг газарт удаан хугацаагаар амьдарч байгаа хүмүүсийг хамруулна. Өрхийг бүхэлд нь эдийн засгийн нэгж гэж үзнэ.

Хуулийн этгээд

Өмчлөлдөө буюу эзэмших ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаврыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдлийг хуулийн этгээд гэнэ. ([Иргэний хуулийн 25.1 заалт](#))

Хуулийн этгээд гэж хуулиар зөвшөөрөгдсөн, хувь хүн болон бусад субъектээс хараат бус, өмч эзэмшигчдийнхээ удирдлага хяналтад ажилладаг нэгжийг ойлгоно. Энд аж ахуйн нэгж байгууллага, ашгийн бус байгууллага, засгийн газрын байгууллага зэрэг эдийн засгийн үйл ажиллагаа болон ажил үйлчилгээ явуулж буй нэгжүүдийг хамруулна. Хуулийн этгээд нь зорилго, чиг үүрэг, шинж төрхөөсөө хамаарч эдийн засгийн секторуудад хуваагддаг.

Эдийн засгийн үйл ажиллагаа

Нийгмийн бүхий л түвшинд явагдаж байгаа бараа, үйлчилгээний үйлдвэрлэл, хуваарилалт, хэрэглээний үйл явцыг ойлгоно.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар

Хуулийн этгээдийн эрхэлж байгаа үйлдвэрлэл, үйлчилгээг үйл ажиллагааны чиглэлээр нь бүлгүүдэд харьяалуулан судлахыг хэлнэ. Эдийн засгийн салбарууд нь үйл ажиллагааны чиглэлээс хамаарч эдийн засгийн секторт ангилагдана.

Эдийн засгийн сектор

Эдийн засгийн нэгж болон салбаруудыг зорилго, чиг үүрэг, шинж төрхөөр нь ангилан хуваарилахыг эдийн эдийн засгийн сектор гэнэ.

Эдийн засгийн харьяат

“Эдийн засгийн харьяат (цаашид харьяат)” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин сууж байгаа Монгол улсын иргэд, гадаад оронд 1 жил хүртэлх хугацаагаар түр оршин сууж байгаа Монгол Улсын иргэд, Монгол Улсын нутаг дэвсгэр дээр 1 жилээс дээш хугацаагаар оршин сууж байгаа гадаадын иргэд, Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллага, тэдгээрийн салбар, төлөөлөгчийн газар, Монгол Улсаас гадаад орнуудад суугаа элчин сайдын яам, консулын болон байнгын төлөөлөгчдийн газар, тэдгээрт ажилладаг Монгол Улсын иргэд, цэргийн албан хаагч гэр бүлийн гишүүдийн хамт, гадаад оронд сурч байгаа болон гадаадад урт, богино хугацаагаар эмчлүүлж байгаа Монгол Улсын иргэдийг хэлнэ.

Эдийн засгийн харьяат бус

“Эдийн засгийн харьяат бус” (цаашид харьяат бус) гэж эдийн засгийн харьяатад хамрагдахгүй гадаад орны болон Монгол Улсын иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудыг хэлнэ.

Гурав. Эдийн засгийн нэгж, түүний хэлбэр

Эдийн засгийн нэгж нь өөрийн эрхийн хүрээнд өмч эзэмших, өр төлбөр үүсгэх, эдийн засгийн үйл ажиллагаанд оролцох, бусад хуулийн этгээдтэй ажил гүйлгээ хийх чадвартай нэгж юм.

Эдийн засгийн нэгж дараах 4 онцлог шинжтэй.

1. Өөрийн эзэмшлийн өмч хөрөнгөтэй, түүнийгээ бусад эдийн засгийн нэгжтэйгээ харилцан солилцох, худалдах, шилжүүлэх бүрэн эрхтэй.
2. Эдийн засгийн үйл ажиллагаанд оролцогчийн хувьд аливаа шийдвэрийг бие даан гаргах чадвартай түүгээрээ хариуцлагыг бүрэн хүлээдэг.
3. Санхүүгийн өр төлбөр, гүйлгээ хийх, хөрөнгө оруулалт авах чадвартай.
4. Санхүүгийн иж бүрэн тайлан тэнцлийг гаргадаг байх, хуулийн хариуцлага хүлээх чадвартай.

Эдийн засагт зохион байгуулалтын үндсэн 2 нэгж байна.

- Өрх (өрхийн аж ахуй эрхлэгчид)
- Хуулийн этгээд (аж ахуйн нэгж, байгууллага)

Өрх нь эдийн засгийн нэгж болох нь:

Өөрийн эцсийн хэрэглээнд, эсвэл зах зээлд борлуулахаар үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг өрхүүдийг өрхийн аж ахуйд хамруулна. Өрх нь үйлдвэрлэгч байхаас гадна зах зээлд ажиллах хүч нийлүүлэгч, эцсийн хэрэглэгч байна. Өрх нь зөвхөн өөрийн хэрэглээг хангах үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах төдийгүй эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааг эрхэлж болно. Өрхийн үйл ажиллагааны цар хүрээ нь үүсгэсэн зорилгодоо хязгаарлагддаг хуулийн этгээдийг бодвол илүү өргөн байдаг. Тухайлбал, өрхийн гишүүн нь аж ахуйн нэгж байгуулснаар, эсвэл өөрийн хөдөлмөрийг бусад нэгжид нийлүүлж хөлсний ажилчин болсноор үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулдаг.

Өрхийн гишүүд өөрийн хөрөнгийг зээлдүүлж, мөн бусдаас зээлдэж болно. Аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж буй өрхийн гишүүд нь бие даасан нэгжийн хэлбэрээр бус харин өөрийн өрхийн нэрийн өмнөөс үйл ажиллагаагаа явуулж байна гэж үздэг. Өрхийн нэг гишүүн хувийн аж ахуйн нэгжтэй бол тэр нь өрхийн салшгүй нэг хэсэг болно.

Хуулийн этгээд нь дараах эдийн засгийн нэгжүүдэд хуваагдана

Төрийн байгууллага эдийн засгийн нэгж болох нь

Төрийн өмчит үйлдвэрийн газраас бусад улсын төсвөөс санхүүждэг хуулийн этгээдийг төрийн байгууллага гэнэ. Төрийн байгууллага нь хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх засаглалын үйл ажиллагааг хэрэгжүүлэх удирдлагын аппарат бөгөөд засаглалын бүтэц нь орон нутгийн удирдлагад нэгэн адил зохион байгуулагдсан байна.

Төрийн байгууллагын өөрийн үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр нь аж ахуйн нэгж, иргэдээс улсын төсөвт төвлөрөх татварын орлого байна. Татвар төлөх нь төрийн өмнө аж ахуй эрхлэгчдийн хуулиар хүлээсэн заавал биелүүлэх үүрэг бөгөөд энэ талаасаа төрийн орлого бүрдэж буй механизм нь эдийн засгийн бусад субъектээс зарчмын ялгаатай.

Төрийн байгууллага, түүнийг төлөөлсөн байгууллагууд нийгэмд хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд зориулан орлогын сан буюу татварыг эдийн засаг, нийгмийн зорилтыг шийдвэрлэхэд чиглүүлэн зарцуулна. Төр, засгийн байгууллага үйл ажиллагаандаа зориулж орлого бүрдүүлэн, мөн түүнийгээ тодорхой чиглэлээр зарцуулж байгаагийн хувьд эдгээр нь

эдийн засгийн секторт хамаарах нэгж болно.

Төрийн байгууллагын эцсийн зардлыг түүний үйл ажиллагааны онцлогийн дагуу дараах 3 чиглэлээр зарцуулна. Үүнд:

1. Улс орны нийтлэг удирдлага болох төрийн удирдлага, батлан хамгаалах, нийгмийн аюулгүй байдал, хэв журам сахиулах зэрэг үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх;
2. Хүн амд үнэ төлбөргүй буюу хөнгөлөлттэй үнээр үзүүлдэг нийгмийн үйлчилгээний (боловсрол, соёл, шинжлэх ухаан, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал болон тэтгэмж зэрэг) зардлыг санхүүжүүлэх;
3. Улсын төвлөрсөн орлого буюу баялгийн дахин хуваарилалт (төрөл бүрийн татаас, санхүүжилт гэх мэт) хийх зэрэг болно.

Аж ахуйн нэгж байгууллага

Эдийн засгийн үйл ажиллагаанд оролцогч хуулиар зөвшөөрөгдсөн хувь хүн, бусад субъектээс хараат бус, өмч эзэмшигчдийнхээ удирдлага, хяналтад ажилладаг аж ахуйн нэгж, байгууллагуудыг дараах байдлаар ангилна.

Төрийн байгууллага - Төрийн өмчит үйлдвэрийн газраас бусад улсын төсвөөс санхүүждэг хуулийн этгээдийг төрийн байгууллага гэнэ.

Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар - Дан ганц төрийн эсвэл орон нутгийн өмчид үндэслэсэн болон улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг үйлдвэрийн газрыг төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар гэх бөгөөд тэдгээрийг эд хөрөнгийн эрхийн байдлаар нь аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, улсын болон орон нутгийн төсөвт үйлдвэрийн газар гэж ангилна.

Компани – Хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь тодорхой тооны хувьцаанд хуваагддаг, өөрийн тусгайлсан эд хөрөнгөтэй, үндсэн зорилго нь ашгийн төлөө хуулийн этгээдийг компани гэнэ. Компани нь хязгаарлагдмал хариуцлагатай болон хувьцаат компани гэсэн хэлбэртэй байна.

Хоршоо - Эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээгээ хангах зорилгоор хэд хэдэн этгээд сайн дураараа нэгдсэн, ардчилсан, хамтын удирдлага, хяналт бүхий, дундын эд хөрөнгө дээр үндэслэн үйл ажиллагаа явуулахаар хамтран байгуулсан хуулийн этгээдийг хоршоо гэнэ.

Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл - Нөхөрлөлийн хүлээсэн үүргийг гишүүд нь нөхөрлөлд оруулсан эд хөрөнгө болон хувийн өмчийн эд хөрөнгөөрөө хамтран хариуцдаг нөхөрлөлийг бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл гэнэ.

Зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл - Нөхөрлөлийн хүлээсэн үүргийг наад зах нь нэг гишүүн нөхөрлөлд оруулсан хөрөнгө болон хувийн өмчийн эд хөрөнгөөрөө бүрэн хариуцдаг, бусад гишүүд нь гагцхүү нөхөрлөлд оруулсан хөрөнгийнхөө хэмжээгээр хариуцдаг нөхөрлөлийг зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл гэнэ.


Төрийн бус байгууллага - Иргэд, төрийн байгууллага /хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх байгууллага/-аас бусад хуулийн этгээдээс нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс сайн дурын үндсэн дээр байгуулагдан үйл ажиллагаагаа төрөөс хараат бус, өөрийгөө удирдах зарчмаар явуулдаг ашгийн төлөө бус байгууллагыг хэлнэ.

Төрийн бус байгууллагад ашгийн бус нам, эвсэл, сан, мэргэжлийн холбоод, хоршоо, шашны байгууллага хамарна. Төрийн бус байгууллагууд нь зах зээлийн болон зах зээлийн бус үйл ажиллагаа эрхэлдэг гэсэн 2 төрөлтэй байна. Үүнд:

- Зах зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг ашгийн бус байгууллагад гарч байгаа өртөг зардалдаа үндэслэж ашиг олох зорилгоор бус боловч үйлчилгээний тариф буюу төлбөр тогтоож иргэдэд үйлчилдэг ашгийн бус байгууллагууд. Энд ихэвчлэн боловсрол, эрүүл мэнд, санхүүгийн зуучлал зэрэг салбарт үйл ажиллагаа эрхэлдэг ашгийн бус байгууллагуудыг хамруулна.
- Зах зээлийн бус ашгийн бус байгууллагад бүтээгдэхүүн, үйлчилгээгээ огт төлбөргүй буюу эсвэл бүтээгдэхүүний тоо хэмжээнд нөлөөлөхгүй байх үнээр хэрэглэгчдэд нийлүүлдэг нэгжүүд. Эдгээр байгууллага нь санхүүгийнхээ гол эх үүсвэрийг гишүүдийн хандив тусламжаар авахын зэрэгцээ тэдэнд Засгийн газар болон бусад байгууллагууд дэмжин туслалцаа үзүүлдэг.

Эдийн засгийн нэгжийг тохирох секторт хуваарилах үндсэн зарчмыг *Зураг 1*-т үзүүлэв.

ЗУРАГ 1: НЭГЖИЙГ ЭДИЙН ЗАСГИЙН СЕКТОРТ ХУВААХ НЬ



Эх үүсвэр: YTC 2008, зураг 4.1

- *Зах зээлийн үйлдвэрлэл нь эдийн засгийн ач холбогдолтой үнээр зах зээлд борлуулсан, борлуулах гэж буй бүтээгдэхүүн, бараа солилцоо, хөдөлмөрийн хөлсөнд бэлнээр олгосон бараа, дуусаагүй үйлдвэрлэл, салбар нэгжүүддээ нийлүүлсэн үйлчилгээнээс бүрдэнэ.*
- *Зах зээлийн бус үйлдвэрлэл нь өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага, төрийн байгууллагаас эдийн засгийн бусад нэгжүүд, нийгэмд бүхэлд нь зориулж үйлдвэрлэдэг, тэдгээрийг үнэ*

төлбөргүйгээр эсвэл эдийн засгийн ач холбогдолгүй үнээр нийлүүлдэг хувийн ба хамтын хэрэглээний бараа, үйлчилгээнээс бүрдэнэ.

Дөрөв. Эдийн засгийн сектор, түүний ангилал

Эдийн засгийн нэгж болон салбаруудыг зорилго, чиг үүрэг, шинж төрхөөр нь ангилан хуваарилахыг эдийн эдийн засгийн сектор гэнэ.

Эдийн засгийн секторыг дотоод эдийн засгийн сектор (S1), гадаад эдийн засгийн сектор (S2) гэж хоёр ангилна.

ҮТС-д үйлдвэрлэл – хэрэглээ – хуримтлал гэсэн эдийн засгийн 3 үндсэн үйл ажиллагааг бүртгэнэ.

- Үйлдвэр, аж ахуйн нэгж нь үйлдвэрлэл, хуримтлалын үйл ажиллагааг эсвэл алийг нь явуулах боловч эцсийн хэрэглээний үйл ажиллагааг явуулахгүй.
- Засгийн газар нь хүн амынхаа өмнөөс эцсийн хэрэглээ, хуримтлал болон үйлдвэрлэл (ихэнхдээ корпорациас өөр төрлийн) явуулна.
- Өрх нь хэрэглээний үйл ажиллагааг явуулах бөгөөд заримдаа хуримтлал, үйлдвэрлэл явуулж болно.
- Ашгийн бус байгууллагууд шинж төрхөөрөө ялгаатай. Зарим нь Засгийн газрын үйл ажиллагааны нэг хэсгийг гүйцэтгэх боловч бие даасан байна.

Дээрх шинж чанарыг харгалзан дотоод эдийн засгийн нэгжүүдийг 5 секторт ангилна. Үүнд:

- Санхүүгийн бус
- Санхүүгийн
- Төрийн байгууллага
- Өрхийн аж ахуй
- Өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага

Эдийн засгийн нэгж болон секторуудын уялдааг дараах хүснэгтээр харуулав.

Эдийн засгийн нэгж болон эдийн засгийн секторын уялдаа

Хүснэгт 1

		Эдийн засгийн сектор				
		Санхүүгийн бус (S11)	Санхүүгийн (S12)	Төрийн байгууллагын (S13)	Өрхийн аж ахуйн (S14)	ӨҮАББ-ын (S15)
Эдийн засгийн нэгж	Аж ахуйн нэгж	<i>Санхүүгийн бус</i>	<i>Санхүүгийн</i>			
	Төрийн байгууллага			<i>Төрийн байгууллага</i>		
	Өрхийн аж ахуй				<i>Өрхийн аж ахуй</i>	
	Ашгийн бус байгууллага (АББ)	<i>Санхүүгийн бус зах зээлийн ААБ</i>	<i>Санхүүгийн зах зээлийн ААБ</i>	<i>Засгийн газрын санхүүжилт бүхий АББ</i>		<i>Зах зээлийн бус өрхөд үйлчилдэг АББ</i>

3.1 Санхүүгийн бус сектор: (S.11)

Санхүүгийн бус секторт зах зээлд борлуулахаар бүтээгдэхүүн, үйлчилгээ үйлдвэрлэж, санхүүгийн бус үйлчилгээ үзүүлж, орлогоороо зардлаа нөхдөг бие даасан аж ахуйн нэгжийг хамруулна. Мөн үйлдвэрлэл, үйлчилгээний салбар буюу санхүүгийн бус салбарт зах зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй ашгийн бус байгууллагыг энэ секторт хамруулна.

Тэдгээрийг дотор нь:

- Төрийн өмчит санхүүгийн бус аж ахуйн нэгж байгууллага;
- Хувийн хэвшлийн санхүүгийн бус ААНБ, дотоодын;
- Гадаадын эзэмшлийн санхүүгийн бус ААНБ гэсэн 3 дэд хэсэгт хуваана.

Төрийн өмчит санхүүгийн бус ААНБ (S.111)

Төрийн байгууллагын удирдлага дор санхүүгийн бус салбарт үйл ажиллагаагаа явуулдаг аж ахуйн нэгж буюу дан ганц төрийн өмчийн болон улсын төсвөөс санхүүждэг үйлдвэрийн газрыг оруулах бөгөөд эд хөрөнгийн эрхийн байдлаар нь аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, улсын төсөвт үйлдвэрийн газар гэж ангилна. Төр өөрийн хяналтыг дараах хэлбэрээр хэрэгжүүлнэ. Үүнд:

- Тухайн аж ахуйн нэгжийн санал өгөх хувьцааны багцыг худалдаж авснаар, эсвэл саналын талаас илүү хувьд хяналт тавих хэлбэр тогтоосноор;
- Тухайн аж ахуйн нэгжийн бодлого тодорхойлох эсвэл удирдлагыг нь томилох эрхийг төрийн удирдлагын байгууллага олгосон, тусгайлсан хууль, тогтоомж, тушаалыг баталснаар хэрэгжүүлнэ.

Хувийн хэвшлийн санхүүгийн бус ААНБ, (S.112)

Төрийн байгууллагын болон гадаадын харьяат нэгжийн удирдлага, хяналтанд байдаггүй, тухайн улсын харьяат санхүүгийн бус хувийн хэвшлийн бүх аж ахуйн нэгж, мөн санхүүгийн бус бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлдэг арилжааны зорилготой ашгийн бус байгууллагыг хамруулна. Жишээ нь: эрүүл мэнд, боловсролын үйлчилгээг төлбөртэйгээр үзүүлдэг байгууллага, мэргэжлийн холбоод зэрэг болно. Мөн манай улсын эдийн засгийн уламжлалт салбар болох МАА, газар тариалан эрхэлж буй компани, аж ахуйн нэгж энд багтана. Харин МАА, газар тариалангийн үйл ажиллагаа эрхэлж буй өрх орохгүй. Эдгээр нь өрхийн секторт хамаарна.

Гадаадын эзэмшлийн санхүүгийн бус ААНБ (S.113)

Гадаадын байгууллагын хяналтан дор үйл ажиллагаа явуулдаг тухайн улсын харьяат санхүүгийн бус бүх аж ахуйн нэгжийг хамруулна. Үүнд:

- Гадаадын эзэмшлийн ААНБ-ын салбар /гадаадын эзэмшлийн ААНБ-ын холбоог оруулахгүй/

Тухайн улсын нутаг дэвсгэрт урт хугацааны туршид бүтээгдэхүүн, үйлчилгээ эрхэлдэг гадаадын аж ахуйн нэгж, байгууллага багтана.

3.2 Санхүүгийн сектор: (S.12)

Санхүүгийн секторт эдийн засгийн бусад нэгжүүдэд санхүүгийн үйлчилгээг үзүүлдэг харьяат бүх аж ахуйн нэгжүүдийг, мөн даатгалын болон тэтгэврийн үйлчилгээг оруулна. Түүнчлэн санхүүгийн салбарт зэх зээлийн үйлчилгээ үзүүлдэг ашгийн бус байгууллагуудыг энэ секторт хамруулна.

Санхүүгийн үйлчилгээ нь үйлдвэрлэлийн бусад үйл ажиллагаанаас онцлог ялгаатай бөгөөд эдийн засгийн үйл ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэдэг учраас ҮТС-ийн секторын

ангилалд бие даасан сектор болно. Санхүүгийн секторт дараах эдийн засгийн нэгжүүд хамаарна. Үүнд:

- а/ Харьяат бүх санхүүгийн компани (ҮТС-д тодорхойлсноор, зөвхөн хуулиар байгуулагдсан компаниар хязгаарлагдахгүй), хувьцаа эзэмшигчдийн харьяалал үүнд үл хамаарна.
- б/ Эдийн засгийн нутаг дэвсгэрт удаан хугацаагаар санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх харьяат бус аж ахуйн нэгжийн салбарууд;
- в/ Санхүүгийн үйлчилгээг зах зээлд санал болгож буй, харьяат ашгийн бус бүх байгууллага;

Санхүүгийн компаниудыг санхүүгийн зуучлагчид, санхүүгийн туслах үйлчилгээ эрхлэгчид болон санхүүгийн бусад гэж 3 хуваана.

Санхүүгийн зуучлагчид гэж санхүүгийн эх үүсвэрийг татан төвлөрүүлж улмаар санхүүгийн хэлцэл хийх замаар санхүүгийн активыг худалдан авч буй ААНБ юм. Үүнд даатгалын байгууллага болон тэтгэврийн сан багтана.

Санхүүгийн туслах үйлчилгээ эрхлэгчид гол төлөв санхүүгийн захад үйлчилгээ үзүүлэх боловч хэлцэлд орж буй санхүүгийн актив, пассивыг эзэмшдэггүй байна.

Санхүүгийн бусад компани гэдэгт нээлттэй зах дээр актив, пассив нь арилжаалагддаггүй санхүүгийн үйлчилгээг үзүүлдэг аж ахуйн нэгж хамаарна. Санхүүгийн компанийг үйл ажиллагааных нь дагуу дэд секторт хувааж болохоос гадна ашгийн болон ашгийн бус байгууллага гэж ангилна.

Санхүүгийн секторт хамаарах нэгжийг өмчийн хэлбэрээр дараах байдлаар ангилна. Үүнд:

- Төрийн өмчит санхүүгийн байгууллага
- Дотоодын хувийн хэвшлийн санхүүгийн байгууллага
- Гадаадын эзэмшлийн санхүүгийн байгууллага

ҮТС 2008 зөвлөмжид санхүүгийн үйлчилгээ, санхүүгийн зах зээл болон санхүүгийн хэрэгсэл дэх өөрчлөлт хөгжлийг тусгахын тулд санхүүгийн секторын дэд секторыг шинэчилсэн.

Санхүүгийн секторыг үйл ажиллагааны төрөл болон пассивын хөрвөх чадвараас хамаарч 9 дэд секторт хуваана. Эдгээр 9 дэд секторыг доорхи хүснэгтэд харуулсан бөгөөд 6-р дэд сектор нь санхүүгийн туслах үйлчилгээ эрхлэгчид бол 7-р дэд сектор нь санхүүгийн бусад компанид хамаарна. Санхүүгийн зуучлагчдыг бусдад хамруулна.

Санхүүгийн дэд секторын ҮТС -1993-ын өөрчлөлтийг дараах хүснэгтээр харуулвал:

ҮТС-1993, ҮТС-2008-ийн санхүүгийн секторын дэд секторуудын уялдаа

ҮТС-1993 санхүүгийн корпорацийн дэд секторууд			ҮТС-2008 санхүүгийн корпорацийн дэд секторууд		
Төв банк	S.121	⇒	S.121	Төв банк	
Хадгаламжийн бусад байгууллага, нэгж	S.122	⇓	S.122	Төв банкнаас бусад хадгаламжийн банкууд	

			S.123	Мөнгөний захын сангууд	
Даатгалын байгууллага, тэтгэврийн сангаас бусад санхүүгийн зуучлагчид	S.123		S.124	Мөнгөний захын бус хөрөнгө оруулалтын сан	
			S.125	Бусад санхүүгийн зуучлал	
Санхүүгийн туслах нэгж	S.124		S.126	Санхүүгийн туслах нэгж	
			S.127	Кэптив санхүүгийн байгууллага болон мөнгө зээлдүүлэгч	
Даатгалын байгууллага ба тэтгэврийн сан	S.125		S.128	Даатгалын байгууллага	
			S.129	Тэтгэврийн сан	
Санхүүгийн бус корпораци	S.11		S.11	Санхүүгийн бус корпораци	

Санхүүгийн дэд секторын ангилал

1. Төв банк
2. Төв банкнаас бусад хадгаламжийн байгууллага
3. Мөнгөний захын хөрөнгө оруулалтын сан
4. Мөнгөний захын бус хөрөнгө оруулалтын сан
5. Тэтгэврийн сан, даатгагчаас бусад санхүүгийн зуучлагч
6. Санхүүгийн туслах үйлчилгээ эрхлэгч
7. Кэптив санхүүгийн байгууллагууд болон мөнгө зээлдүүлэгч
8. Даатгагч
9. Тэтгэврийн сан

3.2.1 Төв банк (S.121)

Монгол Улсын хэмжээнд төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага нь Монголбанк байна. Төв банк нь мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах, эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлтийг зохицуулах замаар мөнгөний бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх, Засгийн газрын санхүүгийн зуучлалын үүрэг гүйцэтгэх, арилжааны банкны үйл ажиллагаанд хяналт тавих, банк хоорондын төлбөр тооцоог зохион байгуулах, гадаад валютын нөөцийг эзэмших, зохицуулах үүрэгтэй.

3.2.2 Төв банкнаас бусад хадгаламжийн байгууллага (S.122)

Энэ секторт Төв банкнаас бусад санхүүгийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж хамаарна. Эдгээр байгууллагын үндсэн үйл ажиллагаа нь санхүүгийн зуучлал бөгөөд тэдгээр нь хадгаламж болон мөнгөний нийлүүлэлтийн нэг хэсэг болох богино хугацаатай хадгаламжийн сертификат зэрэг санхүүгийн хэрэгслийн хэлбэрээр хөрөнгө татан төвлөрүүлнэ.

Энэ дэд бүлэгт дараах санхүүгийн зуучлагчдыг оруулна. Үүнд:

- а/ Арилжааны банк

- б/ Хадгаламжийн банк (үүнд итгэмжлэгдсэн хадгаламжийн банк болон хадгаламж, зээлийн хоршоодыг оруулна);
- в/ Тусгайлсан банкууд болон хадгаламж татан төвлөрүүлдэг буюу хадгаламжтай төстэй хэрэгслүүд гаргадаг санхүүгийн бусад байгууллага;

3.2.3 Мөнгөний захын хөрөнгө оруулалтын сан (S.123)

Мөнгөний захын сан нь олон нийтэд хувьцаа гаргах замаар хөрөнгө босгодог хөрөнгө оруулалтын сан юм. Мөнгөний захын сан нь богино хугацаатай, зээлийн эрсдэл хамгийн багатай үнэт цаасны хөрөнгө оруулалт хийдэг тогтмол орлоготой хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэг төрөл юм. Мөнгөний захын сангийн хувьцааг чек бичих эсвэл гуравдагч талын шууд төлбөрийн бусад хэрэгслээр шилжүүлж болно. Хөрөнгө оруулж буй эдгээр хэрэгсэл нь мөн чанарын хувьд хадгаламжтай адил юм.

3.2.4 Мөнгөний захын бус оруулалтын сан (S.124)

Мөнгөний захын бус хөрөнгө оруулалтын сан нь олон нийтэд хувьцаа гаргах замаар хөрөнгө босгодог хөрөнгө оруулалтын сан юм. Ийнхүү босгосон хөрөнгийг юуны түрүүнд урт хугацаатай санхүүгийн актив болон санхүүгийн бус активт (голдуу үл хөдлөх хөрөнгө) хөрөнгө оруулдаг. Хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа нь хадгаламжтай адилтгах хэрэгсэл байж чаддаггүй. Мөнгөний захын бус хөрөнгө оруулалтын сангийн хувьцааг чек бичих эсвэл гуравдагч талын шууд төлбөрийн хэрэгслээр шилжүүлэхийг хориглоно.

3.2.5 Тэтгэврийн сан, даатгагчаас бусад санхүүгийн зуучлагч (S.125)

Тэтгэврийн сан, даатгагчаас бусад санхүүгийн зуучлагч нь бэлэн мөнгө, хадгаламж, түүнтэй адилтгах хэрэгслээс бусад хэлбэрээр үүрэг хүлээх замаар санхүүгийн зах дээр хэлцэл хийж санхүүгийн активыг худалдан авч санхүүгийн үйлчилгээ үзүүлнэ. Тайлан тэнцлийн хоёр талын гүйлгээг нээлттэй зах дээр хийдэг нь санхүүгийн зуучлагчдын онцлог юм.

Дараах санхүүгийн зуучлагчдыг энэ бүлэгт ангилна.

- а/ **Активыг үнэт цаасжуулах** санхүүгийн байгууллага. Үүнд: Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасан барьцаат болон баталгаат үнэт цаас гаргах чиг үүрэг бүхий тусгай зориулалтын компани;
- б/ Үнэт цаас болон санхүүгийн үүсмэл хэрэгслийн дилер (өөрийн хөрөнгөөр үйл ажиллагаа явуулах);
- в/ Зээл олгох санхүүгийн компани, үүнд жижиглэн худалдаатай холбоотой санхүүгийн түншүүд орно (тэд санхүүгийн түрээс, иргэдийн болон байгууллагын санхүүжилтийг хариуцдаг байж болно);
- г/ **Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төвийн харилцагч** байгууллага. Эдгээр байгууллага нь үнэт цаас, санхүүгийн үүсмэл хэрэгслийн клирингийн болон төлбөр тооцооны гүйлгээг хийнэ. Клиринг нь оролцогч хоёр талын үүрэг хариуцлагыг тодорхойлдог бол төлбөр тооцоо нь үнэт цаас, санхүүгийн үүсмэл хэрэгслийн солилцоо болон холбогдох төлбөртэй холбоотой юм. Клирингийн харилцагч байгууллагууд гүйлгээ хийж **харилцагч талын хүлээж болзошгүй** эрсдлийг багасгана;
- д/ Дараах үйл ажиллагаа явуулдаг санхүүгийн төрөлжсөн компани:

- Аж ахуйн нэгжийн нэгдэл болон өөртөө нэгтгэн нийлүүлэхэд зориулсан богино хугацааны санхүүжилт;
- Экспорт/импортын санхүүжилт;
- Факторингийн үйлчилгээ;
- Венчур болон хөгжлийн капиталын пүүс.

3.2.6 Санхүүгийн туслах үйлчилгээ эрхлэгч (S.126)

Санхүүгийн туслах үйлчилгээ эрхлэгчид гэж гол төлөв санхүүгийн актив, пассивын хэлцэл эсвэл уг хэлцлийн зохицуулалтай холбоотой (актив, пассивыг эзэмшихэд чиглээгүй) үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийг хэлнэ.

Энэ дэд секторт дараах санхүүгийн туслах үйлчилгээ эрхлэгчдийг оруулна:

- а/ Даатгалын мэргэжлийн оролцогч буюу даатгалын төлөөлөгч, даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч (даатгагч болон даатгуулагчийн нэрийн өмнөөс даатгалын гэрээтэй холбоотой нэхэмжлэлийг хянан шалгах, бодит хохирлыг тогтоох, талуудын хооронд хэлэлцээ хийх чиг үүргийг бие даан хэрэгжүүлэх, хэрэгжүүлсний төлөө цалин хөлс болон бусад төлбөр авах эрх бүхий этгээдийг), даатгалын болон тэтгэврийн зөвлөх үйлчилгээ эрхлэгч;
- б/ Зээлийн брокер, үнэт цаасны брокер, хөрөнгө оруулалтын зөвлөх зэрэг;
- в/ Үнэт цаасны арилжааг удирдаж байршуулах байгууллага;
- г/ Үндсэн үйл ажиллагаа нь вексель болон түүнтэй адилтгах хэрэгслийг баталгаажуулах байгууллага;
- д/ Своп, опшин, фьючерс зэрэг санхүүгийн үүсмэл хэрэгсэл болон эрсдлээс хамгаалах хэрэгслийг зохицуулах (хэрэгслүүдийг гаргах бус) байгууллага;
- е/ Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийг бий болгох байгууллага;
- ё/ Тэтгэврийн сан, хамтын сан зэргийн менежер (гэхдээ тэдгээрийг удирддаг сан орохгүй);
- ж/ Хөрөнгийн бирж болон даатгалын биржийн үйлчилгээ үзүүлэх байгууллага;
- з/ Гадаад валютын арилжаа эрхлэх ББСБ;
- и/ Санхүүгийн байгууллагуудад үйлчилгээ үзүүлдэг, бие даасан хуулийн этгээд болох ашгийн бус байгууллага;
- й/ Санхүүгийн үйл ажиллагаа шууд эрхэлдэггүй, харин санхүүгийн байгууллага эсвэл нэгдэлд хяналт тавих үүрэгтэй санхүүгийн байгууллагын удирдлага;
- к/ Санхүүгийн зах болон зуучлагчдад хяналт шалгалтыг хэрэгжүүлэх төв байгууллага (тусдаа зохион байгуулалтын нэгж болох үед);

3.2.7 Кэптив санхүүгийн байгууллагууд болон мөнгө зээлдүүлэгч (S.127)

Кэптив санхүүгийн байгууллагууд болон мөнгө зээлдүүл нь санхүүгийн үйлчилгээ үзүүлж буй аж ахуйн нэгжүүд бөгөөд тэдгээрийн актив, пассивын дийлэнх нь санхүүгийн нээлттэй зах зээл дээр арилжаалагдаггүй байна. Үүнд тодорхой тооны нэгжүүд дотор хэлцэл хийж буй аж ахуйн нэгжүүд (тухайлбал, охин компаниудтай), нэг холдинг компаний охин компаниуд, аль эсвэл зөвхөн нэг спонсорын эх үүсвэрээс зээл олгож буй аж ахуйн нэгжүүдийг хамруулна.

Энэ дэд секторт дараах санхүүгийн аж ахуйн нэгжүүдыг оруулна.

- а/ Итгэмжлэгч, эд хөрөнгийн, агентуудын данс хариуцсан, бүртгэлийн хаяг дээрээ байдаггүй компаниуд (brass plate companies) зэрэг хуулийн этгээдүүд.
- б/ Бүлэг охин компаниудынхаа зөвхөн активыг эзэмшиж (хувьцааны хяналтын багцыг эзэмших) буй холдинг компаниуд. Холдинг компаниуд хувьцааг нь

эзэмшиж буй аж ахуйн нэгжид ямар нэг үйлчилгээ үзүүлэхгүй, өөрөөр хэлбэл бусад нэгжийг удирдахгүй.

в/ Эдийн засгийн нэгжийн шаардлага хангасан, толгой компанидаа нээлттэй зах дээр хөрөнгө босгож буй тусгай зориулалттай компани.

г/ Цэвэр өөрийн аль эсвэл спонсорын хөрөнгөөр (тодорхой хүрээний харилцагчдад) санхүүгийн үйлчилгээ үзүүлж, зээлийн эрсдэлийг хүлээж буй дараах нэгжүүд:

- Зээл олгогчид;
- Засгийн газрын байгууллага болон ашгийн бус байгууллагаас авсан хөрөнгөөс зээл олгох (Тухайлбал: оюутны зээл, экспорт, импортын зээл олгох зэрэг) байгууллага;
- Барьцаалан зээлдүүлэх газар.

3.2.8 Даатгагч(S.128)

Даатгагч гэж эдийн засгийн нэгж (болон бүлэгт)-д амь нас, гэнэтийн осол, өвчлөлт, гал түймэр болон бусад даатгалын үйлчилгээг үзүүлж буй хувьцаат, хамтын болон бусад аж ахуйн нэгжийг ойлгоно. Тэд мөн даатгалын байгууллагууд давхар даатгалын үйлчилгээ үзүүлж байж болно. Даатгалын үйлчилгээг зөвхөн эзэмшигчдэд үзүүлдэг охин/салбар даатгалын байгууллагуудыг мөн үүнд оруулна. Даатгалын хуурамж авах, нөөц бүрдүүлэх, хадгаламжийн баталгаа болон бусад стандарт баталгаа гаргах замаар даатгалын үйл ажиллагаа явуулдаг байгууллагыг даатгагчид хамруулна. Дахин үзэх.

3.2.9 Тэтгэврийн сангууд (S.129)

Өрхийн гишүүн тэтгэврийн орлогыг бүрдүүлэх үүднээс Засгийн газар, ажил олгогч нь нийгмийн даатгалын шимтгэлийг төлөхийг хуулиар тогтоох, дэмжиж урамшуулах үед тэтгэврийн өглөг үүснэ. Нийгмийн даатгалын тогтолцоог ажил олгогчид, Засгийн газар, ажиллагч төлөөлсөн даатгалын байгууллагууд, тэтгэврийн санг удирдах тусгайлсан эдийн засгийн нэгжүүд бүрдүүлнэ. Тэтгэврийн сангийн дэд сектор нь зөвхөн нийгмийн даатгалын тэтгэврийн сангаас бүрдэх бөгөөд нийгмийн даатгалын сангаас тусдаа эдийн засгийн нэгж байна.

3.3 Төрийн байгууллагын сектор: (S13)

Төрийн байгууллага улс орны хэмжээнд дараах 2 түвшинд үйл ажиллагаагаа хэрэгжүүлнэ. Үүнд:

- Улсын төвлөрсөн удирдлагын түвшин (Тухайлбал, Ерөнхийлөгчийн тамгын газар, Улсын Их хурал, Засгийн газар, түүний бүтцийн яам, агентлаг)
- Орон нутгийн удирдлагын түвшин (аймаг, нийслэл, сум, дүүргийн хурал, захиргааны байгууллага, тэдгээрийн бүтцэд хамаарах байгууллага, нэгж)

Төрийн байгууллага үйлдвэрлэгч болох нь:

Төрийн байгууллага нь арилжааны бус зорилготой үйлдвэрлэгч байх бөгөөд бүтээгдэхүүнээ нийгмийн тодорхой хэрэгцээнд зориулан үнэ төлбөргүй буюу хөнгөлөлттэй үнээр нийлүүлдэг онцлогтой.

Төрийн байгууллагын секторыг дараах дэд секторуудад ангилна. Үүнд:

3.3.1 Төрийн төв байгууллага /S.131/

Төрийн төв байгууллага нь Ерөнхийлөгчийн тамгын газар, Улсын Их хурал, Засгийн газар, тэдгээрийн бүтцийн байгууллага, мөн түүний хяналтанд байж санхүүждэг ашгийн бус

байгууллага, нэгжүүдээс бүрдэнэ.

Засгийн газар нь гүйцэтгэх засаглалын дээд байгууллага болохын хувьд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, нэгдсэн төсвийн төслийн болон дунд хугацааны үндсэн үзүүлэлтийг боловсруулах, төсвийн хүрээний мэдэгдэл, түүнд үндэслэн улсын төсвийн төслийг боловсруулах, улсын төсвийн байгууллагын үндсэн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээний санхүүжилтийг тодорхойлох зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3.3.2 Бүсийн удирдлага /S.132/

Бүсийн удирдлага нь төрийн байгууллагын үйл ажиллагааг бүсийн хэмжээнд зохион байгуулж явуулах ба Засгийн газрын үйл ажиллагааг бүсийн түвшинд хэрэгжүүлэх чиг үүрэгтэйгээр ажиллана. Тэдгээрийн үйл ажиллагааны хүрээ нь тухайн бүсдээ л хамаарна.

3.3.3 Орон нутгийн удирдлага /S.133/

Орон нутгийн удирдлагын дэд сектор нь тухайн нутаг дэвсгэр дээр төрийн байгууллагын чиг үүргийг гүйцэтгэдэг нэгж болон тэдгээрийн хяналтан дор үйл ажиллагаа явуулдаг ашгийн бус байгууллага, нэгжээс бүрдэнэ. Орон нутгийн удирдлагын байгууллага нь өөрийн нутаг дэвсгэртээ хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, байгууллага, иргэдээс хууль, тогтоомжийн дагуу албан татвар, хураамж авч, зориулалтын дагуу захиран зарцуулах, иргэний бүх төрлийн бүртгэлийн үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулах зэрэг чиг үүрэгтэй.

Орон нутгийн удирдлагын байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой эрх нь засгийн газрын үйл ажиллагаатай ижил байна. Зах зээлийн бус үнээр бүтээгдэхүүн, үйлчилгээ нийлүүлэгч эмнэлэг, сургууль зэрэг байгууллага нь төрийн байгууллагын нэгж буюу орон нутгийн удирдлагад багтана.

3.3.4 Нийгмийн хамгааллын сан /S.134/

Нийгмийн хамгааллын үйл ажиллагаа, түүнийг эрхлэх байгууллага нь төрийн байгууллагын хүрээнд онцлог байр суурь эзэлдэг. Төрийн байгууллагын секторын нэг чухал бүтэц болох нийгмийн хамгааллын үйлчилгээнд өндөр настан, тэжээгчээ алдагчид, тахир дутуу бологчид болон олон хүүхэд төрүүлсэн эхчүүдэд олгох асрамж, тэтгэмж зэрэг үйл ажиллагаа хамаарна.

Нийгмийн хамгааллын сан нь нийгмийн даатгалын сангаас хөрөнгөө бүрдүүлдэг бөгөөд түүнийг хуулийн дагуу зориулалтаар нь хуваарилах өөрийн эрх, үүрэгтэй.

3.4 Өрхийн аж ахуй: /S.14/

Өрхийн аж ахуйд өөрийн эцсийн хэрэглээнд эсвэл зах зээлд борлуулахаар үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг өрхийг хамруулна. Өрхүүд нь үйлдвэрлэгч байхаас гадна зах зээлд ажиллах хүч нийлүүлэгч, эцсийн хэрэглэгч байна. Өрхийн аж ахуйн үйлдвэрлэгчид нэгдэн хоршдоггүй бөгөөд тайлан тэнцэл гаргах боломжгүй байдаг.

Өрх үйлдвэрлэгч болох нь:

Өрхийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа нь өрхийн гишүүдийн дангаараа буюу хамтран эзэмшиж буй нэгжид тулгуурлана. Хэрвээ өрхийн гишүүд өөр аж ахуйн нэгж, төрийн байгууллагад ажиллаж байвал үйлдвэрлэлийн үйл ажиллагаа нь өрхийн аж ахуйн секторын үйлдвэрлэлийн хүрээнээс ангид явагдаж байна гэж үзнэ.

Өрхийн аж ахуйн үндсэн болон бусад актив нь түүний эзэмшигчийн өмч байна. Өрхийн аж ахуй нь хуулийн этгээдийн нэг адил бусад аж ахуйн нэгжтэй арилжаанд орох, гэрээ хэлцэл хийх, өөрийн нэрийн өмнөөс өр төлбөр тавих эрхгүй байдаг. Иймд аж ахуйн эзэд нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд гарч болох өр төлбөрт хувийн хариуцлага хүлээнэ.

Өрхийн аж ахуйн эзэн нь нэг талаас өрхийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн бизнес хүн, нөгөө талаас хөлсний ажилчинтай ялгаагүй өөрийн хөдөлмөрийг үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд нийлүүлж буй хөлсний ажилчин байна. Өрхийн аж ахуйг эзэмшигч нь бизнес хүний хувьд үйлдвэрлэл явуулахад шаардагдах хөрөнгө, тохирох орон байр, тоног төхөөрөмж, материалыг өөрөө олж эзэмших, түүнчлэн ажилчдыг хөлсөөр ажиллуулж, хяналт тавих шаардлага гарч болно.

Өрхийн байгуулсан аж ахуйн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны ашиг нь 2 төрлийн орлогоос бүрдэж байна гэж үзэж, түүнийг "холимог орлого" гэж нэрлэнэ. Бизнес эрхэлсний орлого болон хийсэн ажлын цалин, хөлс хоёрын харьцаа нь өрхийн аж ахуйн хэлбэрээс шалтгаалж ихээхэн өөрчлөгдөж болно, ихэнх тохиолдолд нарийн зааг ялгааг гаргахад хүндрэлтэй байдаг.

Өрхийн байгуулсан арилжааны зорилготой аж ахуй:

Өрхүүд зах зээл дээр борлуулах, аль эсвэл солилцох бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үйлчилгээг явуулахын тулд арилжааны зорилготой үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх аж ахуйг байгуулж болно. Ийм төрлийн аж ахуй нь өөрийн гэсэн үндсэн хөрөнгөгүй, тогтсон ажлын байргүй, дан ганц худалдаачин эсвэл гутал тослогчоос эхлээд олон ажиллагчидтай боловсруулах үйлдвэр, барилга, үйлчилгээний салбарын томоохон ААНБ ч байж болно.

Өрхийн арилжааны зорилготой үйлдвэрлэгчийн бүтээгдэхүүний нэг хэсэг нь эзэмшигчийн өрхийн хэрэглээнд зарцуулагдаж болно.

Өөрийн эцсийн хэрэглээнд зориулан үйлдвэрлэгч өрх:

Өрх өөрийн эцсийн хэрэглээнд зориулж тодорхой нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлэх зорилгоор үйл ажиллагаа эрхэлж болно. Өрхийн эцсийн хэрэглээнд зарцуулсан бүтээгдэхүүн, үйлчилгээний өртгийг зах зээл дээр борлуулагдаж буй ижил төстэй бүтээгдэхүүн, үйлчилгээний үнээр тооцно.

Өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэлээ явуулж буй өрхийн аж ахуй нь дараахь хэлбэртэй байна. Үүнд:

- а/ өөрийн эцсийн хэрэглээнд зориулж ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг малчин, тариачны болон бусад аж ахуй;
- б/ өөрийн хэрэглээнд зориулж орон сууц буюу бусад барилга байгууламж барьж байгаа болон орон сууц, барилга байгууламжийг өргөтгөж, засварлаж байгаа өрх;
- в/ өөрийн хэрэглээнд зориулж бусад төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж буй өрх эдгээр болно.

Өрхийн аж ахуй нь өөрийн хэрэгцээнээс илүүдэл бүтээгдэхүүнийг борлуулж болно. Гэхдээ бүтээгдэхүүн, үйлчилгээний үндсэн хэсгийг байнга борлуулдаг бол арилжааны зорилготой өрхийн аж ахуй буюу үйлдвэрлэгч өрхийн аж ахуй болно.

Өрхүүдийн орлогын гол эх үүсвэрийг дараах төрлүүдэд хуваана:

- а/ ажил олгогчийн холимог орлого буюу өрхийн аж ахуйн үйлдвэрлэлдээ хүн хөлслөн ажиллуулдаг эзэмшигчийн олж байгаа холимог орлого
- б/ хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн холимог орлого буюу хөлсний хөдөлмөрийг ашигладаггүй, өөрөө ажилладаг эзэмшигчийн олж байгаа холимог орлого
- в/ өрхийн аж ахуйд ажилладаг хөлсний ажилчдын хөдөлмөрийн орлого
- г/ өмч болон шилжүүлгийн орлого - өөрийн эзэмшлийн газар, байгалийн нөөц, санхүүгийн хөрөнгийг гэрээний үндсэн дээр бусдад эзэмшүүлж, үйлдвэрлэлийн үйл

ажиллагаанд нь оролцохгүй зөвхөн ашиг, орлогоос нь хувь хүртэх замаар авсан орлого (хувьцааны орлого, газар түрээслүүлсний орлого, байгалийн баялгаа ашиглуулсны орлого, санхүүгийн хөрөнгө зээлдүүлсний орлого г.м), нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн орлого, даатгалын орлого гэх мэт шилжүүлгийн орлогууд

Өрхийн аж ахуйн секторын өрхийг тухайн өрхийн орлогын эх үүсвэрээр нь 4 дэд секторт ангилна. Үүнд:

а/ Ажил олгогч /S.141/

б/ Хувиараа хөдөлмөр эрхлэгч /S.142/

в/ Хөлсний ажиллагчид /S.143/

г/ Өмчийн болон шилжүүлгийн орлого хүртэгчид /S.144/

Тухайлбал, ажил олгогч гэсэн дэд секторт тухайн өрхийн орлогын эх үүсвэрийн дийлэнхийг ажил олгогчийн холимог орлого нь бүрдүүлдэг өрхүүд орно. Орлогын үндсэн эх үүсвэр нь өмчийн болон шилжүүлгийн орлогоос бүрддэг өрхүүдийг дараах 3 төрөлд хуваана. Үүнд:

а/ Өмчийн орлого хүртэгчид

б/ Тэтгэвэр авагчид

в/ Шилжүүлгийн орлого хүртэгчид

Тэтгэвэр авагч өрхүүдэд орлогын үндсэн эх үүсвэр нь удаан жил ажилласны тэтгэвэр буюу бусад тэтгэврээс бүрддэг өрхүүдийг хамруулна.

3.5 Өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага /S.15/

Ашгийн бус байгууллага нь үүсгэн байгуулагч болон санхүүжүүлэгч, удирдах нэгждээ ашиг олох хэрэгсэл нь болдоггүй, зах зээлд бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үйлчилгээг явуулах зорилготой байгуулагдсан хуулийн этгээд юм. Ашгийн бус байгууллагууд нь санхүүгийн болон санхүүгийн бус салбарт зах зээлийн болон зах зээлийн бус үйл ажиллагаа эрхэлж болох онцлогтой.

Зах зээлийн бус үйл ажиллагаа эрхэлж, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагыг дотор нь гишүүддээ үйлчилдэг болон нийгэмд үйлчилдэг ашгийн бус байгууллага гэж хоёр үндсэн дэд секторт хувааж авч үздэг. Тэдгээр нь бараа, бүтээгдэхүүнийг борлуулах, үйлчилгээг үзүүлэхдээ үнэ төлбөргүй юм уу, эсвэл зах зээлийн үнээс доогуур үнээр борлуулдаг онцлогтой.

Өөрийн гишүүдэд үйлчилдэг, тэдний хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үндсэн зорилготой, нийгэмд үйлчилдгээс бусад ашгийн бус байгууллагыг гишүүддээ үйлчилдэг ашгийн бус байгууллага гэнэ. Үүнд: худалдааны нийгэмлэг, хэрэглэгчдийн холбоо, улс төрийн нам, сүм, хийд болон нийгэм, соёл урлаг, спортын клуб зэрэг орно. Эдгээр нь гишүүдийн ашиг сонирхлын үүднээс үйлчилгээ үзүүлэх зорилгоор байгуулагдсан ашгийн бус байгууллага байна. Эдгээр үйлчилгээ нь үнэ төлбөргүй бөгөөд гишүүнчлэлийн татвараар санхүүжнэ.

Соёл, урлаг, боловсрол, хүмүүжил, шинжлэх ухаан, эрүүл мэнд, спорт, байгаль орчин, орчин ахуйн хөгжил, хүний эрх, хүн амын тодорхой бүлэг, давхаргын эрх ашгийг хамгаалах, энэрлийн зэрэг чиглэлээр нийгмийн тусын тулд үйл ажиллагаа явуулдаг бол нийгэмд үйлчилдэг ашгийн бус байгууллага болно.

Төрийн байгууллага, ААНБ болон хувь хүмүүс ашгийн бус байгууллагыг байгуулдаг. Тухайлбал, өөрийн ашиг сонирхлын үүднээс өөрт үйлчлүүлэхээр, түүнчлэн буяны,

энэрлийн, нийгмийн сайн сайхны тусын тулд, эрүүл мэндийн болон боловсролын үйлчилгээг үнэгүй хүргэх зорилгоор, бизнесийн болон улс төрийн дарамтанд буй бүлгүүдэд дэмжлэг үзүүлэх зэрэг олон нөхцөл шалтгаан байна.

Ашгийн бус байгууллагын шинж чанар

- а/ Арилжааны бус зорилгоор бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг өрх гэрт болон хэсэг бүлэг өрхүүдэд зориулан үйлдвэрлэдэг.
- б/ Олонх ашгийн бус байгууллагын гишүүд нь тэнцүү эрхтэй байна. Гишүүд нь бүгдээрээ шийдвэр гаргахад адил тэнцүү эрхтэй байна.
- в/ Ашгийн бус байгууллагад ашиг болон хөрөнгийг эзэмшигч гэж байхгүй. Гишүүд нь байгууллагад орсон орлогыг хувааж авахгүй, олсон орлого нь ашгийн бус байгууллагад үлдэнэ.

Өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагыг дараах 2 дэд секторт ангилдаг. Үүнд:

3.5.1 Гишүүддээ үйлчилдэг ашгийн бус байгууллага /S.151/

Гишүүдийн ашиг сонирхлын үүднээс бараа болон анхан шатны үйлчилгээ үзүүлэх зорилгоор байгуулагдсан ашгийн бус байгууллага байна. Бараа үйлчилгээ нь үнэ төлбөргүй байх бөгөөд ба гишүүнчлэлийн татвараар санхүүжнэ. Жишээ нь худалдааны нийгэмлэг, хэрэглэгчдийн холбоо, улс төрийн нам, сүм хийд болон нийгэм, соёл, урлаг, спортын клубыг оруулна.

3.5.2 Хүмүүнлэгийн үйл ажиллагаа эрхэлдэг ашгийн бус байгууллага /S.152/

Энэ нь буяны болон аюулд нэрвэгсдэд үзүүлэх тусламжийн байгууллагаас бүрдэх бөгөөд нийгэмлэгийн гишүүдийн ашиг сонирхолд үйлчилдэггүй бөгөөд бусад нэгжээс санхүүжнэ.

3.5.3 Хамтын үйлчилгээ үзүүлдэг ашгийн бус байгууллага /S.153/

Хамтын үйлчилгээ үзүүлдэг ашгийн бус байгууллага нь судалгааны байгууллага, байгаль орчны групп зэргээс бүрдэх бөгөөд судалгааны үр дүнгээ олон нийтэд үнэ төлбөргүй хүргэнэ. Эдгээр байгууллага нь дээрх хоёр дэд сектортой харьцуулахад нийтлэг бус бөгөөд тухайн улсыг төлөөлж чадахгүй байх талтай.

Тав. Гадаад эдийн засгийн сектор

Дотоодын эдийн засагт тухайн орны нутаг дэвсгэрт байрлаж байгаа эдийн засгийн харьяат болон харьяат бус бүх хүмүүсийн үйл ажиллагааг хамруулдаг бол гадаад эдийн засгийн сектор манай улсын эдийн засгийн харьяатууд болон бусад орнуудын нэгжүүдийн (эдийн засгийн харьяат бус) хооронд хийгдсэн эдийн засгийн үйл ажиллагааг бүртгэнэ.

Эдийн засгийн харьяат гэсэн ойлголт иргэний харьяаллаас ялгаатай. Эдийн засгийн сонирхлын төв нь тухайн орны эдийн засгийн нутаг дэвсгэртэй холбоо бүхий аж ахуйн нэгж, байгууллага, хүмүүсийг энэ орны эдийн засгийн харьяат гэнэ. Аль нэг орны эдийн засгийн нутаг дэвсгэрт эдэлбэр газар, барилга байшин эзэмшигч нь өөр улсын харьяат байсан ч тухайн оронд эдийн засгийн сонирхлын төвтэй гэж үзэн тухайн орны эдийн засгийн харьяат гэнэ. Өөрөөр хэлбэл, тухайн орны эдийн засгийн нутаг дэвсгэр дээр жилээс дээш хугацаагаар үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж байгаа үйлдвэр, байгууллага, өрхийн аж ахуй, хүмүүсийг тэр орны эдийн засгийн харьяат гэж ойлгоно.

Практикт жилээс доош хугацаагаар ирсэн гадаадын жуулчид, жүжигчид, эрдэмтэд, улирлын чанартай ажилчид, түүнчлэн нэлээд удаан хугацаагаар суурьшдаг гадаадын дипломат төлөөлөгчид, тэдгээрийн гэр бүлийн гишүүд, гадаадын цэргийн албан хаагчдаас

бусад гадаад, дотоодын харьяат бүх иргэд, аж ахуйн нэгж, байгууллага тухайн орны эдийн засгийн харьяатууд болно.

Олон улсын байгууллага

Тухайн улсын нутаг дэвсгэрт оршдог гадаадын элчин сайдын яам, цэргийн бааз, олон улсын байгууллага нь гадаад эдийн засгийн секторт хамаарна. Үүнд:

- а/ Олон улсын байгууллага нь гишүүн орнуудын хоорондын зөвшилцлийн үндсэн дээр байгуулагддаг бөгөөд олон улсын хэлэлцээрийн статустай байна. Түүний оршин тогтнох нь гишүүн улсуудын хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн байна.
- б/ Үл хамаарах статустай, түүнчлэн оршин буй улсынхаа харьяат болохгүй ба тухайн орны хуулинд захирагдахгүй байдаг.

Хавсралт 1: ҮТС 2008-д оруулсан Эдийн засгийн секторын ангилалтай холбогдох өөрчлөлт

1. Тусгай зориулалтын этгээдийг хүлээн зөвшөөрсөн.

ҮТС 2008-д ажилчингүй эсвэл санхүүгийн бус хөрөнгөгүй нэгжийг тусгай зориулалтын этгээд, тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл гэж үзнэ гэсэн зааварчилгааг оруулсан. Тусгай зориулалтын этгээдийн нийтлэг тодорхойлолт гэж байхгүй боловч дараах онцлог шинжтэй байна. Бодит байдал дээр бага хэмжээгээр оршдог, ихэвчлэн өөр нэг корпоративтай холбоотой (ихэвчлэн охин компаний хэлбэрээр) байх, өөрийн толгой компаний харьяалагддаг нутаг дэвсгэрээс өөр нутаг дэвсгэрийн харьяат байх зэрэг тодорхойлолт байдаг.

Ийм нэгжийг эдийн засгийн нэгж гэж үзэх бөгөөд дараах гурван ангиллын аль нэгэнд нь хамаарахгүй бол үндсэн үйл ажиллагааных нь дагуу сектор болон салбарт хуваарилна. (а) Барьцаалан зээлдэх газар (Өөр салбарт хамаарах), (б) Корпорацийн зохиомол салбар компани (в) Төрийн байгууллагын тусгай зориулалтын нэгж.

ҮТС 1993-д эдгээр нэгжийг ингэж үзэх талаар тодорхой зааварчилгаа өгөөгүй байдаг.

2. Холдинг компанийг санхүүгийн секторт хуваарилсан.

Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал 4 (ЭЗБТҮАСА,2011) -ийн К хэсгийн 6420-г холдинг компанийг салбар компанийнхаа активыг эзэмшдэг ч удирдлагын үйл ажиллагаа эрхэлдэггүй зөвхөн санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг нэгж гэж тодорхойлсон. ҮТС 2008-ын дагуу холдинг компанийн бүх дэд сектор нь санхүүгийн бус байсан ч гэсэн үргэлж санхүүгийн секторд хуваарилах бөгөөд **барьцаалан зээлдэх газар** гэж үзэх хэрэгтэйг зөвлөсөн.

ҮТС 1993-д холдинг компанийг салбар компаниудын үндсэн үйл ажиллагаа төвлөрөх эдийн засгийн секторт хуваарилж байсан. Тиймээс эдгээрийн хяналт тавих корпорацийн бүлгийн үндсэн үйл ажиллагаа нь санхүүгийнх байх үед л эдгээрийг санхүүгийн сектор гэж ангиллаж байсан.

3. Толгой компанийг салбар компанийнх нь дийлэнх болох эдийн засгийн секторт хуваарилсан.

“Холдинг компани” гэсэн нэр томъёог заримдаа буруу ашигладаг бөгөөд “толгой компани” гэх нь илүү зөв юм. ЭЗБТҮАСА-4, М хэсгийн 7010-д зааснаар толгой компаний үйл ажиллагаанд бизнесийн байгууллага болон бусад байгууллагын менежментийн асуудалд зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа; стратегийн эсвэл зохион байгуулалтын төлөвлөлт боловсруулах, компани эсвэл үйлдвэрийн газрын шийдвэр гаргахад удирдах дээд байгууллагын үйл ажиллагаа багтана. Энэ үйл ажиллагааг явуулж байгаа нэгж нь өөрийн харьяа, доод нэгжийн өдөр тутмын үйл ажиллагааг хянаж, зохицуулна. Тиймээс ийм нэгж нь салбар корпорацийнхаа үйлдвэрлэлтээс шалтгаалж санхүүгийн эсвэл санхүүгийн бус үйлчилгээ явуулна. ҮТС 2008-д толгой компаний салбар корпорацийн бүх эсвэл ихэнх нь санхүүгийн сектор биш бол санхүүгийн бус секторт хуваарилах хэрэгтэйг зөвлөсөн, мөн бол уламжлал ёсоор санхүүгийн секторт санхүүгийн туслах үйлчилгээ эрхлэгчид гэнэ.

ҮТС 1993-д толгой компаний талаар тодорхой зааварчилгаа өгөгдөөгүй.

4. Ашгийн бус байгууллагын дэд секторыг бий болгосон.

ҮТС 1993-ын адилаар ҮТС 2008-д АББ-ын сонирхол, татварын статус, ажиллагчдын төрөл, үйл ажиллагааны төрлөөс нь хамаарахгүйгээр эдийн засгийн өөр өөр секторт хуваарилсан. “Иргэний нийгмийн” баталгаа болсон АББ-ыг авч үзэх сонирхол нэмэгдсэн. Үүнтэй холбоотой ҮТС 2008 зөвлөмжинд корпорацийн болон төрийн байгууллагын сектор доторх АББ-ыг тусад нь дэд сектор болгож АББ бүх үйл ажиллагааг дүгнэх нэмэлт хүснэгт нь шаардлагатай үед тусдаа шууд бий болно.

5. Санхүүгийн үйлчилгээний тодорхойлолтыг өргөжүүлсэн.

Санхүүгийн зуучлалаас бусад санхүүгийн үйлчилгээний өсөлт, ялангуяа санхүүгийн эрсдлийн менежмент болон хөрвөх чадварын өөрчлөлтийг мэдэж байхыг батлахын тулд ҮТС 2008 нь ҮТС 1993-аас санхүүгийн үйлчилгээг илүү тодорхой тайлбарласан. Санхүүгийн үйлчилгээнд мониторингийн үйлчилгээ, тав тухтай байдлын үйлчилгээ, хөрвөх чадварын нөөц, эрсдлийн таамаглал, даатгалын болон худалдааны үйлчилгээ орно.

6. Санхүүгийн үйлчилгээ, зах зээл болон хэрэгслийн шинэ хөгжлийг тусгахын тулд санхүүгийн секторын дэд секторын хуваарилалт шинэчлэгдсэн.

ҮТС 2008-д ОУВС, Европын төв банк зэрэг мөнгө, санхүүгийн статистикийн бусад системд илүү уян хатан, сайтар нийцүүлэхийн тулд санхүүгийн секторын илүү дэлгэрэнгүй ангиллыг оруулсан. Санхүүгийн секторыг зах зээлийн нэгжийнх нь үйл ажиллагаа болон пассивынх нь хөрвөх чадварын дагуу 9 дэд секторт (ҮТС 1993-т 5 байсан) хуваасан. Дэд секторууд нь:

1. Төв банк
2. Төв банкнаас бусад хадгаламжын байгууллага
3. Мөнгөний захын хөрөнгө оруулалтын сан
4. Мөнгөний захын бус хөрөнгө оруулалтын сан
5. Тэтгэврийн сан, даатгагчаас бусад санхүүгийн зуучлагч
6. Санхүүгийн туслах үйлчилгээ эрхлэгчид
7. Барьцаалан зээлдэх газар
8. Даатгагч
9. Тэтгэврийн сан

Улс орнуудад мөнгийг тодорхойлох үнэлэмж нь өөр байдгаас шалтгаалж ҮТС 2008-д мөнгөний тодорхойлолтыг оруулаагүй. Гэхдээ санхүүгийн сектор, хэрэгслийн ангиллыг мөнгөний үндэсний тодорхойлолттой нийцүүлж оруулсан. “Мөнгөний захын сан” –г тусад нь салгах учир эдгээрийг оруулах эсвэл оруулахгүй ч байж болно.

**Хавсралт 2. Монгол Улсын нутаг дэвсгэрт харьяалах
ААНБ-ыг сектороор ангилах нь**

Код	Тодорхойлолт	Харьяалагдах ААНБ
S1. Дотоод эдийн засгийн сектор		
S.11 Санхүүгийн бус сектор		
S.111	Төрийн өмчит санхүүгийн бус үйлдвэрийн газар /ашгийн, ашгийн бус/	Төрийн болон орон нутгийн өмчит санхүүгийн бус үйлдвэрийн газар
S.112	Хувийн хэвшлийн санхүүгийн бус ААНБ /ашгийн, ашгийн бус/	Хувийн хэвшлийн санхүүгийн бус бүх ААНБ, дотоодын
S.113	Гадаадын эзэмшлийн санхүүгийн бус ААНБ /ашгийн, ашгийн бус/	Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын эзэмшлийн санхүүгийн бус бүх ААНБ
S12 Санхүүгийн сектор		
S.121	Төв банк	Монголбанк
S.122	Төв банкнаас бусад хадгаламжийн байгууллага /ашгийн, ашгийн бус/	Арилжааны банк, хадгаламжийн банк, хадгаламж зээлийн хоршоо
S.123	Мөнгөний захын хөрөнгө оруулалтын сан /ашгийн, ашгийн бус/	
S.124	Мөнгөний захын бус хөрөнгө оруулалтын сан /ашгийн, ашгийн бус/	Хөгжлийн банк
S.125	Тэтгэврийн сан, даатгагчаас бусад санхүүгийн зуучлагч /ашгийн, ашгийн бус/	Брокер дилерийн компани, ипотекийн корпорац
S.126	Санхүүгийн туслах үйлчилгээ эрхлэгч /ашгийн, ашгийн бус/	үнэт цаасны хороо, банк бус санхүүгийн гадаад валютын арилжаа эрхлэх ББСБ
S.127	Барьцаалан зээлдэх газар /ашгийн, ашгийн бус/	Барьцаалан зээлдүүлэх газар
S.128	Даатгагч /ашгийн, ашгийн бус/	Даатгалийн байгууллага
S.129	Тэтгэврийн сан /ашгийн, ашгийн бус/	Нийгмийн даатгал

S.13 Төрийн байгууллагын сектор		
S.131	Төрийн төв байгууллага /ашгийн, ашгийн бус/	Төрийн байгууллага
S.132	Бүсийн удирдлага /ашгийн, ашгийн бус/	Бүсийн удирдлага /ашгийн, ашгийн бус/
S.133	Орон нутгийн удирдлага /ашгийн, ашгийн бус/	Орон нутгийн удирдлагын байгууллага
S.134	Нийгмийн хамгааллын сан /ашгийн, ашгийн бус/	Нийгмийн халамжийн байгууллага
S14 Өрхийн аж ахуй		
S.141	Ажил олгогч	
S.142	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	
S.143	Хөлсний ажиллагчид	
S.144	Өмчийн болон шилжүүлгийн орлогыг хүлээн авагч	
S15 Өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага		
S.151	Гишүүддээ үйлчилдэг ашгийн бус байгууллага /дотоодын, гадаадын хөрөнгө оруулалттай/	Гишүүддээ үйлчилдэг ашгийн бус байгууллага
S.152	Хүмүүнлэгийн үйл ажиллагаа эрхэлдэг ашгийн бус байгууллага /дотоодын, гадаадын хөрөнгө оруулалттай/	Хүмүүнлэгийн үйл ажиллагаа эрхэлдэг ашгийн бус байгууллага
S.153	Хамтын үйлчилгээ үзүүлдэг ашгийн бус байгууллага /дотоодын, гадаадын хөрөнгө оруулалттай/	Хамтын үйлчилгээ үзүүлдэг ашгийн бус байгууллага
S.2 Гадаад эдийн засгийн сектор		
S.21	Олон улсын байгууллага	Олон улсын байгууллага
S.22	Валютын холбооны төв банк	

**ҮТС-1993 болон ҮТС 2008 –ийн
Эдийн засгийн секторын ангиллын харьцуулалт**

ҮТС 1993		ҮТС 2008	
S1. Дотоод эдийн засгийн сектор			
S.11 Санхүүгийн бус сектор			
S.111	Төрийн өмчит санхүүгийн бус үйлдвэрийн газар	S.111	Төрийн өмчит санхүүгийн бус үйлдвэрийн газар /ашгийн, ашгийн бус/
S.112	Санхүүгийн бус хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага	S.112	Хувийн хэвшлийн санхүүгийн бус ААНБ /ашгийн, ашгийн бус/
S.113	Гадаадын харъяатын удирдлагатай санхүүгийн бус аж ахуйн нэгж	S.113	Гадаадын эзэмшлийн санхүүгийн бус ААНБ /ашгийн, ашгийн бус/
S12 Санхүүгийн сектор			
S.121	Төв банк	S.121	Төв банк
S.122	Хадгаламжийн бусад байгууллага	S.122	Төв банкнаас бусад хадгаламжийн байгууллага /ашгийн, ашгийн бус/
S.1221	Мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа бүхий аж ахуйн нэгж	S.123	Мөнгөний захын хөрөнгө оруулалтын сан /ашгийн, ашгийн бус/
S.1222	Хадгаламжийн бусад нэгж	S.124	Мөнгөний захын бус хөрөнгө оруулалтын сан /ашгийн, ашгийн бус/
S.123	Тэтгэврийн даатгалаас бусад даатгалын байгууллага, бусад санхүүгийн зуучлагчид	S.125	Тэтгэврийн сан, даатгагчаас бусад санхүүгийн зуучлагч /ашгийн, ашгийн бус/
S.124	Санхүүгийн туслах нэгж	S.126	Санхүүгийн туслах үйлчилгээ эрхлэгч /ашгийн, ашгийн бус/
S.125	Тэтгэврийн даатгалын үйл ажиллагаа эрхлэгч байгууллага	S.127	Барьцаалан зээлдүүлэх газар /ашгийн, ашгийн бус/
		S.128	Даатгалын байгууллага /ашгийн, ашгийн бус/
		S.129	Тэтгэврийн сан /ашгийн, ашгийн бус/

S.13 Төрийн байгууллагын сектор			
S.131	Төрийн төв байгууллага	S.131	Төрийн төв байгууллага /ашгийн, ашгийн бус/
S.132	Бүсийн удирдлага	S.132	Бүсийн удирдлага /ашгийн, ашгийн бус/
S.133	Орон нутгийн удирдлага	S.133	Орон нутгийн удирдлага /ашгийн, ашгийн бус/
S.134	Нийгмийн хамгааллын сан	S.134	Нийгмийн хамгааллын сан /ашгийн, ашгийн бус/
S.14 Өрхийн аж ахуй			
S.141	Ажил олгогч	S.141	Ажил олгогч
S.142	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	S.142	Хувиараа хөдөлмөр эрхлэгч
S.143	Хөлсний ажиллагчид	S.143	Хөлсний ажиллагчид
S.144	Өмчийн болон шилжүүлгийн орлого хүртэгчид	S.144	Өмчийн болон шилжүүлгийн орлогыг хүлээн авагч
S.15 Өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага			
S.151	Гишүүддээ үйлчилдэг ашгийн бус байгууллага	S.151	Гишүүддээ үйлчилдэг ашгийн бус байгууллага /дотоодын, гадаадын хөрөнгө оруулалттай/
S.152	Хүмүүнлэгийн үйл ажиллагаа эрхэлдэг ашгийн бус байгууллага	S.152	Хүмүүнлэгийн үйл ажиллагаа эрхэлдэг ашгийн бус байгууллага /дотоодын, гадаадын хөрөнгө оруулалттай/
		S.153	Хамтын үйлчилгээ үзүүлдэг ашгийн бус байгууллага /дотоодын, гадаадын хөрөнгө оруулалттай/
S2. Гадаад эдийн засгийн сектор			
S.21	Олон улсын байгууллага	S.21	Олон улсын байгууллага
		S.22	Валютын холбооны төв банк